

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/030/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: С.Төмөрхуяг
Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын илрүүлэлт	14
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
АЗС	Авто замын сан
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.21 № 162

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.МӨНГӨНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 9 зорилтын хүрээнд 164 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 91.9 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

011071996

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	147,207,682.0	168,479,832.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	147,207,682.0	168,479,832.0
354	Хангамжийн материал	23,424,758.0	44,696,908.0
35420	Аж ахуйн материал	841,050.0	841,050.0
35470	Бусад хангамжийн материал	22,583,708.0	43,855,858.0
35600	Мал амьтад	123,782,924.0	123,782,924.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,332,191,096.8	2,137,236,289.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,332,191,096.8	2,137,236,289.9
392	Биет хөрөнгө	1,324,640,897.0	2,129,990,115.1
39201	Барилга, байгууламж, орон сууц	464,678,190.6	556,184,257.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,136,132.5)	(46,672,817.8)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155,454,934.0	280,254,934.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(107,507,045.6)	(115,948,564.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,998,750.0	67,589,700.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,648,413.2)	(37,214,393.0)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,440,600.0	49,544,236.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,288,006.7)	(36,976,411.4)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,090,258,594.3	1,379,453,856.3
39215	Хуримтлагдсан элэгдэл	(284,610,574.0)	(390,425,782.7)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	424,201,100.0
393	Биет бус хөрөнгө	7,550,199.8	7,246,174.8
39301	Програм хангамж	3,197,200.0	3,197,200.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,418,600.2)	(1,722,625.2)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,771,600.0	5,771,600.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,479,398,778.8	2,305,716,121.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,479,398,778.8	2,305,716,121.9
51	Засгийн газрын хувь оролцоо	1,479,398,778.8	2,305,716,121.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	581,162,917.3	581,162,917.3
51101	Өмч: - төрийн	581,162,917.3	581,162,917.3
512	Хуримтлагдсан үр дүн	789,969,778.9	1,616,287,121.9
51210	Өмнөх үеийн үр дүн	657,402,830.5	789,969,778.9
51220	Тайлант үеийн үр дүн	132,566,948.4	826,317,343.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,266,082.7	108,266,082.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,479,398,778.8	2,305,716,121.9

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	914,564,154.0	1,938,124,622.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,029,307.0	979,459,685.0
120	Нийтлэг татварын бус орлого	317,029,307.0	979,459,685.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	317,029,307.0	979,459,685.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	571,500.0	566,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	316,457,807.0	978,893,685.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,534,847.0	958,664,937.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,844,247.0	78,980,517.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,894,247.0	59,330,517.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,950,000.0	19,650,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	526,690,600.0	879,684,420.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	377,992,900.0	879,684,420.0
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	148,697,700.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	775,494,161.6	1,103,870,421.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	751,025,161.6	1,072,472,941.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,550,083.0	969,947,739.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	371,263,898.5	604,018,364.7
210101	Үндсэн цалин	270,268,923.7	367,544,330.7
210102	Нэмэгдэл	79,154,205.6	199,881,122.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,663,997.1	5,496,055.0
210104	Урамшуулал	17,176,772.0	31,096,857.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,594,007.2	77,517,641.9
210201	Тэтгэврийн даатгал	31,555,428.9	52,117,709.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,422,400.0	5,775,008.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,954,976.8	5,088,158.9
210204	Ажилгүйдлийн даатгал	694,994.9	1,408,300.2
210205	Эрүүл мэндийн даатгал	6,966,206.7	13,128,464.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,685,580.7	10,725,139.4
210301	Гэрэл, цахилгаан	3,553,105.7	4,095,883.4
210302	Түлш, халаалт	8,532,475.0	6,029,256.0
210303	Цэвэр, бохир ус	600,000.0	600,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	90,256,605.0	28,646,977.0
210401	Бичиг хэрэг	5,230,000.0	7,400,000.0
210402	Тээвэр, шатахуун	14,064,936.0	14,283,307.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,800.0	1,042,800.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.0	626,400.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,375,000.0	2,200,000.0
210408	Бараа материал акталсны зардал	68,393,869.0	3,094,470.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,997,000.0	8,550,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,550,000.0
210604	Урсгал засвар	1,997,000.0	6,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	8,742,000.0	16,542,000.0
210702	Дотоод албан томилолт	8,742,000.0	16,542,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,303,335.0	1,479,842.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.0	880,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	143,850.0	207,600.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,492.0	126,851.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	88,000.0
210807	Газрын төлбөр	71,993.0	177,391.0

**Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,707,656.6	222,467,774.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,244,241.0	79,143,760.6
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,463,415.6	143,324,013.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,475,078.6	102,525,202.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,000.0	22,298,692.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	22,218,692.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.0	80,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,425,078.6	80,226,510.1
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,425,078.6	80,226,510.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,469,000.0	31,397,480.0
2200	Дотоод эх үүсвэрээр	24,469,000.0	31,397,480.0
223001	Бусад хөрөнгө	24,469,000.0	31,397,480.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	139,069,992.4	834,254,201.2
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,503,044.0	7,936,858.1
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	7,936,858.1
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	6,503,044.0	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,503,044.0)	(7,936,858.1)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	132,566,948.4	826,317,343.1

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	598,106,347.0	959,230,937.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	571,500.0	566,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	571,500.0	566,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	571,500.0	566,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	571,500.0	566,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,534,847.0	958,664,937.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,844,247.0	78,980,517.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,894,247.0	59,330,517.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,950,000.0	19,650,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	526,690,600.0	879,684,420.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	377,992,900.0	879,684,420.0
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	148,697,700.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	560,446,347.0	927,833,457.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	560,446,347.0	927,833,457.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,971,268.4	825,308,255.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	371,263,898.5	604,018,364.7
210101	Үндсэн цалин	270,268,923.7	367,544,330.7
210102	Нэмэгдэл	79,154,205.6	199,881,122.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,663,997.1	5,496,055.0
210104	Урамшуулал	17,176,772.0	31,096,857.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,594,007.2	77,517,641.9
210201	Тэтгэврийн даатгал	31,555,428.9	52,117,709.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,422,400.0	5,775,008.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,954,976.8	5,088,158.9
210204	Ажилгүйдлийн даатгал	694,994.9	1,408,300.2
210205	Эрүүл мэндийн даатгал	6,966,206.7	13,128,464.9

**Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,685,580.7	10,725,139.4
210301	Гэрэл, цахилгаан	3,553,105.7	4,095,883.4
210302	Түлш, халаалт	8,532,475.0	6,029,256.0
210303	Цэвэр, бохир ус	600,000.0	600,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,571,736.0	25,552,507.0
210401	Бичиг хэрэг	5,230,000.0	7,400,000.0
210402	Тээвэр, шатахуун	13,648,936.0	14,283,307.0
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,042,800.0	1,042,800.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.0	626,400.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.0	2,200,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,997,000.0	8,550,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,550,000.0
210604	Урсгал засвар	1,997,000.0	6,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	8,742,000.0	16,542,000.0
210702	Дотоод албан томилолт	8,742,000.0	16,542,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,303,335.0	1,479,842.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.0	880,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	143,850.0	207,600.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,492.0	126,851.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	88,000.0
210807	Газрын төлбөр	71,993.0	177,391.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,813,711.0	80,922,760.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,813,711.0	80,922,760.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,475,078.6	102,525,202.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,000.0	22,298,692.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	22,218,692.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.0	80,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,425,078.6	80,226,510.1
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,425,078.6	80,226,510.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	37,660,000.0	31,397,480.0
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,660,000.0	31,397,480.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,660,000.0	31,397,480.0
2200	Дотоод эх үүсвэрээр	37,660,000.0	31,397,480.0
223001	Бусад хөрөнгө	37,660,000.0	31,397,480.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(37,660,000.0)	(31,397,480.0)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	581,162,917.3	108,266,082.7	657,402,830.5	1,346,831,830.5
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	581,162,917.3	108,266,082.7	657,402,830.5	1,346,831,830.5
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.0	0.0	0.0	0.0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.0	0.0	0.0	0.0
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
C07	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	132,566,948.4	132,566,948.4
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	581,162,917.3	108,266,082.7	789,969,778.9	1,479,398,778.8
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	581,162,917.3	108,266,082.7	789,969,778.9	1,479,398,778.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	581,162,917.3	108,266,082.7	789,969,778.9	1,479,398,778.8
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.0
D08	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	826,317,343.1	826,317,343.1
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	581,162,917.3	108,266,082.7	1,616,287,121.9	2,305,716,121.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	880,250,420.0	800,023,909.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	846,385,700.0	768,626,429.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	822,010,600.0	746,327,737.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,486,200.0	603,451,364.7
210101	Үндсэн цалин	382,396,500.0	367,544,330.7
210102	Нэмэгдэл	242,409,900.0	199,881,122.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,040,000.0	5,496,055.0
210104	Урамшуулал	27,639,800.0	30,529,857.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,435,800.0	77,517,641.9
210201	Тэтгэврийн даатгал	56,056,300.0	52,117,709.4
210202	Тэтгэмжийн даатгал	5,275,800.0	5,775,008.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,594,900.0	5,088,158.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,319,000.0	1,408,300.2
210205	Эрүүл мэндийн даатгал	13,189,800.0	13,128,464.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,325,900.0	10,725,139.4
210301	Гэрэл, цахилгаан	4,156,500.0	4,095,883.4
210302	Түлш, халаалт	10,569,400.0	6,029,256.0
210303	Цэвэр, бохир ус	600,000.0	600,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	24,004,100.0	24,002,600.0
210401	Бичиг хэрэг	7,200,000.0	7,400,000.0
210402	Тээвэр, шатахуун	12,733,400.0	12,733,400.0
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,044,000.0	1,042,800.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	626,700.0	626,400.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.0	2,200,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,986,000.0	8,550,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,986,000.0	2,550,000.0
210604	Урсгал засвар	6,000,000.0	6,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	15,000,000.0	13,916,000.0
210702	Дотоод албан томилолт	15,000,000.0	13,916,000.0

**Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,157,600.0	1,479,842.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,272,200.0	880,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	342,300.0	207,600.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,100.0	126,851.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	141,600.0	88,000.0
210807	Газрын төлбөр	177,400.0	177,391.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,615,000.0	6,685,150.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,615,000.0	6,685,150.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,375,100.0	22,298,692.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,375,100.0	22,298,692.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,102,000.0	22,218,692.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	273,100.0	80,000.0
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,864,720.0	31,397,480.0
2200	Дотоод эх үүсвэрээр	33,864,720.0	31,397,480.0
223001	Бусад хөрөнгө	33,864,720.0	31,397,480.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	880,250,420.0	800,023,909.9
132001	Орон нутгийн төсвөөс	880,250,420.0	800,023,909.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.0	24.0
620001	Удирдах ажилтан	3.0	3.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.0	13.0
620003	Үйлчлэх ажилтан	8.0	8.0
620004	Гэрээт ажилтан	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	93,980,517.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,980,517.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,980,517.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	567,000.0
210104	Урамшуулал	567,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,549,907.0
210402	Тээвэр, шатахуун	1,549,907.0
2107	Томилолт, зочны зардал	2,626,000.0
210702	Дотоод албан томилолт	2,626,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,237,610.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,237,610.6
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	93,980,517.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	93,980,517.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,330,517.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,650,000.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 59,248.9 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгөөр бүртгэх 47,492.6 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалд бүртгэж, зарлагаар давхар бүртгэснийг аудитын явцад залруулсан.
- 880.0 мянган төгрөгийн зардлын ангилал буруу сонгож бүртгэснийг аудитын явцад залруулсан
- Үлдэгдэлгүй бараа материалын бүлгээс зарцуулалт хийж хасах үлдэгдэлтэй бараа материал бүртгэснийг аудитын явцад залруулсан
- Үндсэн хөрөнгө акталсны зардал болох 7,936.9 мянган төгрөгийг үнэ төлбөргүй гарсан бараа материал дансанд бүртгэснийг аудитын явцад залруулсан

Аудитаар нийт 910,576.9 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 3,480.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 907.1 сая төгрөгийн 1 албан шаардлага, нягтлан бодох бүртгэлийг цаг тухай бүр үнэн зөв хөтлөн ажиллаж байх 1 зөвлөмж өгч ажиллалаа.

3.1 Төлбөрийн акт

Цалинг зөрүүтэй тооцож 3,480.6 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.2 Албан шаардлага

Шилэн дансны мэдээлэлд оруулах ёстой 178 мэдээллээс 907.1 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй гэж заасны дагуу шилэн дансны мэдээллийг заасан хугацаанд нь оруулж байх албан шаардлагыг хүргүүлж байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт: Ажилчдын цалингийн зарим нэмэгдлүүдийг дутуу орхигдуулснаар дараа саруудад нөхөж олгох, санхүүгийн тайлангийн зардлын ангиллыг буруу сонгох, дансанд бүртгэлтэй байгаа бараа материалыг зарлагадах, зардлаар давхар бүртгэх зэрэг санхүүгийн бичилтүүдийн алдааг дамтамжтай гаргасан

Өгсөн зөвлөмж: "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 20.2.3. холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэснийг баримтлан ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгөөр бүртгэх хөрөнгийг бараа материалд бүртгэсэн ба актлаагүй байгаа хөрөнгийг бараа материал акталсны зардлаар бүртгэсэн.	1	47,492.6	-	-	1	47,492.6	1	47,492.6	-	-	--	-
Зардлын ангиллыг буруу бүртгэсэн	2	880.0	-	-	2	880.0	2	880.0	-	--		-
Үлдэгдэлгүй бараа материалын бүлгээс зарцуулалт хийж хасах үлдэгдэлтэй бараа материал үүсгэсэн.	1	2,939.5	-	-	1	2,939.5	1	2,939.5	-	-	--	
Үндсэн хөрөнгө акталсны зардлыг үнэ төлбөргүй гарсан бараа материал дансанд бүртгэсэн.	1	7,936.9	-	-	1	7,936.9	1	7,936.9				
Дүн	1	59,248.9	-	-	5	59,248.9	5	59,248.9	-	-	-	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Ажилчдын цалингийн зарим нэмэгдлүүдийг дутуу орхигдуулснаар дараа саруудад нөхөж олгох, санхүүгийн тайлангийн зардлын ангиллыг буруу сонгох, дансанд бүртгэлтэй байгаа бараа	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

**Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

материалыг зарлагдах, зардлаар давхар бүртгэх зэрэг санхүүгийн бичилтүүдийн алдааг дамтамжтай гаргасан.												
Эмнэлгийн магадлагааны дагуу чөлөөтэй байсан ажилчдын цалинг тухайн сард бүтэн тооцож олгосон.	1	1,181.9	1	1,181.9	-	--	-	-	-	-	-	-
Ажилчдын цагийн бүртгэлээр чөлөөтэй, тус чөлөөг цалинтай өгөх дээд шатны удирдлагын шийдвэргүйгээр тухайн сарын цалинг бүтэн тооцож олгосон.	1	2,298.6	1	2,298.6	-	-	-	-	-	-	-	-
Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулах 178 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Үүнд: Байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	1	907,096.3	-	-	1	907,096.3	-	-	-	-	-	-
Дүн	4	910,576.9	2	3,480.6	1	907,096.3	1	-	-	-	-	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 24/А1171311

Чойбалсан хот

АДА-2025/030/ТА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагийн бүртгэлээр чөлөөтэй албан хаагчдад цалин хөлсийг 3.4 сая төгрөгөөр илүү олгосон байна. Энэ нь "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 100.2.Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна гэсний дагуу Булган сумын ЗДТГ-ын 2022 оны 11 сарын 15-ны "Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай" А/107 дугаар тушаалын хавсралт "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.3 болон 8.7.1.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү тооцоолж олгосон цалингийн 3,480,599.0 /гурван сая дөрвөн зуун наян мянга таван зуун ерэн есөн/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн хүү, торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Мөнгөнчимэг, нягтлан бодогч Ө.Мөнхцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА
АУДИТОР  С.ТӨМӨРХУЯГ



2125050064



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 55/А/НБ/11

Чойбалсан хот

ДДА-2025/030/НА-СТА-ТДЗ

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт гэсэн нийт 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь "Шилэн дансны тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудаст хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн мэдээлж байх, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Мөнгөнчимэг, нягтлан бодогч Ө.Мөнхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

С.ТӨМӨРХУЯГ



2125040091